



**МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/462

Мандалговь

**Орон нутгийн чанартай авто замын  
бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх,  
мэдээлэх журам батлах тухай**

Монгол Улсын Авто замын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх, мэдээлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.



ЗАСАГ ДАРГА *[Signature]* О.БАТ-ЭРДЭНЭ

102 дугаар сарын 25-ны өдрийн 1162 дугаар захирамжийн хавсралт



## ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ ЭРХЛЭН ХӨТЛӨХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Энэхүү журмыг аймгийн нутаг дэвсгэр дэх орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжид тооллого, бүртгэл хийх, үндсэн хөрөнгийн бүртгэлд авах, авто замын сүлжээний техникийн үзүүлэлт, ашиглалтын түвшний талаарх өгөгдлүүдийг үндэслэн, excel программ хангамжийг ашиглан бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, эрхлэн хөтлөх, баяжуулах, мэдээлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад мөрдөнө.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Орон нутгийн болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийн бүртгэл мэдээллийн цахим санг авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг оновчтой төлөвлөх, авто зам хэрэглэгчдийг мэдээллээр хангах, авто замын сүлжээний ашиглалтын төлөв байдлыг тогтооход ашиглана.

2.2. Авто зам, замын байгууламжийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах, удирдах ажлыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга хариуцан зохион байгуулж, чиглэл хариуцсан мэргэжилтэн уг санг эрхлэн хөтөлж, баяжуулах үйл ажиллагааг хариуцна.

2.3. Аймгийн Засаг даргын шийдвэрээр бүртгэл мэдээллийн санг хөтлөх, баяжуулах үүргийг шаардлага хангасан мэргэжлийн байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлж болно.

Гурав. Авто замын бүртгэл, мэдээллийн сан

3.1. Авто замын бүртгэл, мэдээллийн сан нь авто зам, замын байгууламжтай холбоотой дараахь мэдээллээс бүрдэнэ:

### 3.1.1. Авто замын мэдээлэл:

1. Техникийн болон ашиглалтын үзүүлэлт;
2. Хүчин чадал, зэрэглэл, төлөв байдал;
3. Замын эрчим;
4. Замын гүүр хоолойн талаарх мэдээлэл;
5. Замын төлөв байдлын мэдээлэл дулааны болон хүйтний улирлаар
6. Замын ангилал, зэрэглэлийг бүр болон түр өөрчилсөн талаар мэдээлэл
7. Төсөвт өртөг, элэгдэл, хорогдлын бүртгэл, мэдээлэл;
8. Ашиглалтад орсон хугацаа;
9. Авто зам, замын байгууламжид хийсэн засварын мэдээлэл;
10. Авто зам, замын байгууламжид гарсан эвдрэл, зам, тээврийн ослын

мэдээ;

11. Авто зам, замын байгууламжийг барьж байгуулсан болон арчлалт, засвар хийсэн байгууллагын талаархи мэдээлэл;

12. Замын дэргэдэх байгууламжийн талаарх мэдээлэл

### 3.1.2. Авто зогсоолын мэдээлэл:

1. Ашиглалтын үзүүлэлт;
2. Хүчин чадал, төлөв байдал;
3. Төсөвт өртөг, элэгдэл, хорогдлын бүртгэл, мэдээлэл;
4. Ашиглалтад орсон хугацаа;

- 5. Авто зогсоолын талбайд хийсэн засварын мэдээлэл;
- 6. Авто зогсоолын талбайг барьж байгуулсан болон арчлалт, засвар хийсэн байгууллагын талаарх мэдээлэл;
- 7. Өмчлөгчийн мэдээлэл;

**3.1.3. Гүүрийн мэдээлэл:**

- 1. Гүүрийн төлөвлөлт, угсралтын талаарх техникийн мэдээлэл, гүүрийн ашиглалтад орсон хугацаа;
- 2. Гүүрийн урт/м;
- 3. Гүүрийн ашиглалтын мэдээлэл;
- 3. Гүүрэнд хийсэн засварын мэдээлэл;
- 4. Гүүрийг барьж байгуулсан болон арчлалт, засвар хийсэн байгууллагын талаархи мэдээлэл;
- 5. Гүүр хариуцагчийн мэдээлэл;

**Дөрөв. Авто замын бүртгэл, мэдээллийн санг эрхлэх хөтлөх**

4.1. Аймгийн нутаг дэвсгэр дэх авто замын бүртгэл мэдээллийн санг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн хариуцсан мэргэжилтэн, сумын нутаг дэвсгэр дэх авто замын бүртгэл мэдээллийн санг тухайн сумын ЗДТГ-ын хөгжлийн бодлогын мэргэжилтэн эрхлэн хөтөлнө.

**Тав. Мэдээллийг хадгалах, архивлах, аюулгүй байдал, хамгаалалт**

5.1. Мэдээллийн санг хөтлөх, баяжуулах үйл ажиллагааг тогтмол, тасралтгүй явуулна.

5.2. Сумдын холбогдох мэргэжилтэн нь мэдээллийн санд өөрчлөлт гарсан тухай бүр шинэчлэн баяжуулж, мэдээллийн үнэн зөв, мэдээллийн сангийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хариуцан ажиллах бөгөөд жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор өөрчлөлтийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.3. Мэдээллийн сангийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах асуудлыг мэргэжилтэн хариуцах бөгөөд жил бүр архивлан хадгална.

**Зургаа. Хориглох зүйл, хүлээлгэх хариуцлага**

6.1. Мэдээллийн санд нэвтрэх эрх бүхий этгээд нь мэдээллийн сангийн нууц мэдээлэл, файлын бүтэц, зохион байгуулалтын талаар аливаа мэдээллийг бусдад дамжуулахыг хориглоно.

6.2. Мэдээллийн сангийн серверт эрх бүхий этгээдээс бусад хүн хандахыг хориглоно.

6.3. Энэхүү журмын заалтуудыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, албан тушаалтанд Авто замын тухай болон Зөрчлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох бөгөөд маргаантай асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.